

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв



Практик
сургалт

DATA DRIVEN MARKETING

(Бизнесийн практик сургалт)

2026.1.19-1.23

2026 он

1) Зорилго:

Data driven marketing нь мэдээлэл харилцаа холбоо, дижитал технологийн хөгжилтэй холбоотойгоор асар их хэмжээний дата үүсч, тархаж байгаа энэ цаг үед Монгол, Япон бизнес эрхлэгчид датаг ашиглан маркетинг хийх, борлуулалтаа өсгөх шаардлагатай болж байна.

Тус сургалтын эхэн үед датад суурилсан маркетингийн үндсэн ойлголтыг авж, статистикийн олон аргыг ашиглан ажлын байран дээрх дата, судалгааны датаг шинжлэх, ашиглах чадварыг эзэмшүүлэх зорилготой юм. Тухайлбал, SNS дата, нээлттэй дата, POS дата гэх мэт, вебийн судалгаа, анкетын загварчлал ба гүйцэтгэл, хөндлөн бөөгнөрөл (cross-tabulation), конжойнт шинжилгээ (conjoint analysis) гэх мэт бүтээгдэхүүний төлөвлөлт, болон регресс шинжилгээ (regression analysis)-ийг ашиглан үйлчилгээний сайжруулалтыг амьдралд хэрэгжүүлж болох практик дасгалууд ажиллана.

Сургалтын хоёрдугаар хэсэгт сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж буй үүсгэгч хиймэл оюун ухааныг маркетингт хэрхэн ашиглах талаар суралцана. Үүсгэгч хиймэл оюун ухааны онцлогийг мэдэж авсанаар зөв ашиглах ур чадвараас суралцах бөгөөд AI ашиглан бүтээгдэхүүний төлөвлөгөө, сурталчилгааны материалуудыг хэрхэн үр дүнтэй боловсруулах талаар суралцана.

Хүлээгдэх үр дүн:

- Үйл ажиллагааны санал асуулгын өгөгдөлд дүн шинжилгээ хийж, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох
- Үүсгэгч хиймэл оюун ухааныг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний загвар гаргах, сурталчилгааг үр дүнтэй болгох

2) Хичээллэх хэлбэр: Танхимаар хичээллэнэ.

3) Хичээллэх өдөр, цаг: 2026.1.19-1.23 (Даваа-Баасан), 09:30-14:00

Завсарлага: 10:50-11:00/10 мин/, 12:20-12:40/20 мин/

4) Хамрагдах хүн: Компанид байгаа датаг бизнесээ өргөжүүлэх, амжилттай явуулахад үр дүнтэйгээр ашиглах маркетингийн аргачлалд суралцахыг хүссэн хүн бүр

Жич: Эксэл программ дээр ажиллаж чаддаг байх

5) Хамрагдах хүний тоо: 30 хүн

※Хүний тоо гүйцсэн тохиолдолд хугацаанаас өмнө бүртгэл дуусахыг анхаарна уу!

6) Сургалтын төлбөр: 425,000 төгрөг

※Суралцагч ямар нэгэн шалтгаанаар сургалтад хамрагдах боломжгүй болсон тохиолдолд сургалтын төлбөрийг буцааж олгохгүй.

※Таны бүртгэл орж ирсний дараа төлбөрийн нэхэмжлэх мэйлээр очих тул та заасан хугацаанд төлбөрөө төлнө үү.

7) Хичээл заах багш:



Фүкүёо Казүхиро
(Ph.D)

- 2002 оноос Ямагүчи их сургуулийн магистрын сургуулийн Инноваци & Технологийн менежментийн тэнхимийн профессор
- 1998-2002 Хитачи компанийн судлаач
- Осакагийн их сургуулийн Инженерийн факультетд магистр, докторын зэрэг хамгаалсан
- Эрдэм шинжилгээний нийт 83 өгүүлэл хэвлүүлсэн

Гадаадад ажилласан туршилага

- 2005 БНХАУ-ын дотоод дээд боловсролын төслийн туршилтын судалгааны гишүүн
- 2007 Камбожид резинэн үйлдвэрлэлийг дэмжих, санхүүгийн чадавхийг хөгжүүлэх мэдлэгийн тусламжийн туршилтын судалгааны гишүүн
- 2009 оноос Лаосын их сургуулийн MBA профессороор ажиллаж байна
- 2011-2015 ЖАЙКА-гийн мэргэжилтэнээр “2011 оны Камбожийн эдийн засаг статистик судалгаа”-г дэмжин ажилласан
- 2017-2021 ЖАЙКА-гийн мэргэжилтэнээр “Балбын эдийн засаг статистик судалгаа”-г дэмжин ажилласан

<https://researchmap.jp/nozomishiina>

8) Хөтөлбөр:

Өдөр		Сургалтын агуулга
1 дэхь өдөр (1 сарын 19)	1	Дижитал шилжилт (DX) Коронавируст халдварын (COVID-19) улмаас маш хурдацтай явагдаж буй DX/DX-ийн үндсэн элементүүд : AI, IoT, өгөгдлийн шинжлэх ухаан/DX-ийн жишээ/дижитал хэрэгслийг ашиглах арга
	2	Өгөгдөлд тулгуурласан маркетингийн элементүүд (Data-Driven Marketing) Маркетингийн тодорхойлолт/ Маркетингийн урсгал/ Өгөгдөлд суурилсан маркетингийн суурь/ Өгөгдөл цуглуулах
	3	Өгөгдлийн шинжилгээ Интернэт ба Е-комерс/ Е-комерс ба өгөгдөл цуглуулах/ Социал медиагийн үр нөлөө
	4	Үйл ажиллагааны өгөгдлийн шинжилгээ

2 дахь өдөр (1 сарын 20)		Төрөл бүрийн үйл ажиллагааны өгөгдлийн тайлбар/ Хүснэгт боловсруулах программ Microsoft Excel ашиглан өгөгдлийг нүдэнд харагдахуйц болгох/ POS өгөгдлийн ашиглалт
	5	Өгөгдлийн шинжилгээ (Дасгал ажил) Microsoft Excel ашиглан үйл ажиллагааны өгөгдөлд регрессийн шинжилгээ хийх
	6	Их өгөгдлийн ашиглалтын жишээнүүд Төрийн албаны байгууллага дахь өгөгдлийн ашиглалтын жишээ/ Улс төр дэх өгөгдлийн шинжлэх ухааны ашиглалт
3 дахь өдөр (1 сарын 21)	7	Кросс хүснэгтийн (Cross Tabulation) ашиглалт Кросс хүснэгтийг ашиглан хэрэглэгчийн шинж чанарт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөлөгөө гаргах
	8	Өгөгдөлд тулгуурласан үйлчилгээг сайжруулах (Дасгал ажил) Хэрэглэгчийн санал асуулгын дүн болон регрессийн шинжилгээнд үндэслэн үйлчилгээг сайжруулалт хийх
	9	Конжоинт шинжилгээгээр дамжуулан бүтээгдэхүүн төлөвлөх (Conjoint Analysis) Конжоинт шинжилгээгээр дамжуулан бүтээгдэхүүн, үйлчилгээний загвар гаргах механизмыг судлах
4 дэхь өдөр (1 сарын 22)	10	Үүсгэгч хиймэл оюун ухаан (Generative AI)-ыг бизнест ашиглах нь Хиймэл оюун ухааны талаарх үндсэн ойлголт /Машин сургалт/ Мэдрэлийн сүлжээ
	11	Хиймэл оюун ухааны хэрэгслүүд ChatGPT, Google Gemini, Microsoft Copilot зэргийг ашиглах арга зам /Ажил дээр ашиглаж болох AI хэрэгслүүдийн танилцуулга (Kreado AI, Gamma, Canva)
	12	Хиймэл оюун ухааныг үр дүнтэй ашиглах арга зам Үүсгэгч хиймэл оюун ухааны үндсэн ажиллагаа /Промпт бичих техникүүд
5 дахь өдөр (1 сарын 23)	13	Хиймэл оюун ухаанд суурилсан бүтээгдэхүүн төлөвлөлт Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн суурь мэдлэг /Үүсгэгч хиймэл оюун ухаан ашиглан бүтээгдэхүүний төлөвлөгөө боловсруулах дасгал ажил /Бүтээгдэхүүний төлөвлөгөө боловсруулах
	14	Хиймэл оюун ухаанд суурилсан сурталчилгаа Идэвхжүүлэлтийн материал боловсруулах (Дасгал ажил /Сошиал медиагаар дамжуулан сурталчилгаа өрнүүлэх
	15	Дүгнэлт Data Driven Marketing талаарх нэгдсэн дүгнэлт/ Суралцагчийн байр суурь, түвшингээс хамааран цаашид юуг илүү гүнзгийрүүлж судлах ёстой талаарх тайлбар

9) Гэрчилгээ: 70-аас дээш хувийн ирцтэй оролцогчдод гэрчилгээ олгоно.

10) Бүртгэл:

1. Бүртгэлийн хугацаа: 2025.12.22 (Даваа) –2026.1.16 (Баасан)

※ Хүний тоо гүйцсэн тохиолдолд хугацаанаас өмнө бүртгэл дуусахыг анхаарна уу!

2. Бүртгүүлэх: Та доорх QR кодыг уншуулж бүртгүүлнэ үү.



10) Холбоо барих:



Хариуцсан ажилтан:

У.Хонгорзул



Утас:

7511-0879 (Ext.3), 8063-0879



Цахим хуудас:

www.japan-center.edu.mn



Фэйсбүүк хуудас:

www.facebook.com/Mojc.business/

